

**“Амраг хонгорын дуулал” хэмээх дууны
зохиогдсон тухай өгүүлэх нь**

Б. Хас-Эрдэнэ

“Монголын Судлал” сэтгүүлийн 1971 (Tom. VIII) дугаарт, эрдэмтэн судлаач У. Загдсүрэн гуай “бичмэл нэгэн дууны тухай” гэх сэдвээр “Ноёдыг магтсан дуу” хэмээх бүтээлийн тухай анхны судалгааны өгүүллийг бичсэн байна. Уг өгүүлэлдээ: “ЗХУ-ын (хуучин нэрээр) Шинжлэх Ухааны Академийн Дорнодахин Судлалын Хүрээлэнгийн Ленинградын салбарын гар бичмэлийн хөмрөгт 21 бадаг, 84 мөр шүлэг бүхий хоёр хуудас хонин цаасан дээр бичсэн <Ноёдыг магтсан дуу> гэсэн монгол үсгийн сонирхолтой нэгэн бичмэл байгааг мэдээлэхийн зэрэгцээ бүтээлийн үндсэн агуулгыг харгалзан 1—11 дүгээр бадаг буюу эхний хэсэгт ихэс дээдсийн тухай, 12—21 дүгээр бадаг буюу эцсийн хэсэгт янаг амрагийн тухай тус тус өгүүлжээ.” хэмээн тэмдэглэжээ. (1) Дээрхи дууны гар бичмэл эхийг үндэслэвэл хоёр хуудас дууны үг өөр өөр агуулгатай бөгөөд, арван нэгэн бадаг бүхий эхний хуудас нь ноёдын магтуу, арван бадаг бүхий хоёрдугаар хуудас нь амрагийн дуу болно. Энэ хоёр хуудас гар бичмэл хол зайдуу нутагт тасаг бусаг зүйл бүтээл боловч Ордос нутагт бол нэлээд өргөн дэлгэрсэн дуу юм. “Эрхэм гурван эрдэнэ” гэх бүтээл нь Ордосын 17-р ээлжийн чуулганы дарга, баруун гарын өмнөд хошууны засаг бэйл Бадрах ноёны төр шашны зэргээр тэтгэсэн үйл ажиллагааг магтсан дуу бөгөөд Зүүнгар болон Далад зэрэг харьцангуй эрт хятаджсан хоёр хошууг эс тооцвол бусад бүх хошуунд үе дамжин дуулагдсаар ирсэн билээ.

Энэхүү “Амраг хонгорын дуулал”-д Бадрах ноёны бага хатан “өргөмжлөлт сэцэн хатан” Занданы үзэсгэлэн төгөлдөр өнгө зүс, мэргэн гэгээн ухаан бодол, хар үсээ цайтал ханилан жаргах гэсэн амлалт... зэрэг нарийн нандин бүхий л зүйлсийг багтаан сайшаан магтсан байгаа юм. Иймээс энэ хоёр бүтээл бол ноён болон хатанд зориулсон ихэр дуу болно. Уг дууны зарим бадгийг түрүү зууны эхээр Ордосын баруун өмнөт хэсгийн Борбалгасанд шашин дэлгэрүүлэгчээр сууж байсан эрдэмтэн А. Мостаэрт “Ордос аман зохиол” доо эмхтгэн оруулсан учраас аль эрт олны хүртээл болсон байгаа юм (2). Гэвч дурдууштай нь “Амраг хонгорын дуулал”-д Бадрах ноён болон бага хатан Занданы янаг хайрыг сайшаан бичсэн биш, харин Их Зуугийн чуулганы дэд дарга агсан, төрийн түшээ гүн Балжир болон Зандан хатны хоорондох янаг амрагийн харьцааг талархан магтсан нь сонирхолтой байгаа юм. Уг дууг Үүшин хошууны баруун биеийн их хүрээний тайж Дамринжаваас Балжир гүнг орлон Сэцэн хатанд зориулан гаргасан байв. Дууны бадагт гарах “улаан туур хулгун өвөртөлсөн” үйл хэргийг Манж Чин улсын үе дэх гадаад монголын төрийг засах яамны “хууль зүйн бичиг”-ээр шүүж, “бусдын богтолсон гэргийг аргалж авах ану” зурваст оногдуулбал, засаг ноёны эмийг аргалан татаж ханилан суусан гүн ноён ядахдаа арваад өрхөө салгаж, чуулганы дарга Бадрах ноёнд төлбөр болгон өгөх ял заагдах учиртай аж (3). Гэвч уг дуулалд энэ алтан урагтны ураг хуримын дүрэм хуулийг самарсан биш, харин гавьяатай болсон юм шиг талархан магтсан байгаа нь

гайхаш төрүүлнэ. Үүнээс үзэхд уг дууллын ард ямар нэгэн ээдрээ будлиантай үйл хэрэг холбогдож байгаа нь аяндаа цухалзна. Эдүгээ холбогдох эл хэргийн тухайд анхаарал хандуулья.

Нэг. Өргөмжлөлт сэцэн хатан Зандан

Их Зуугийн чуулганы Ордос баруун гарын өмнөт хошууны 10-р үеийн засаг, Ордос чуулганы да ноён Бадрахын бага хатныг Зандан гэдэг. Сүйюань хотын харьяат Түмэд баруун хошууны яамны бичээч (тэнхимийн бичээч) -ийн гэрт шар нохой жил (1838) төрсөн байжээ. Түгээмэл Элбэгтийн 4 (1854) -р онд Үүшин хошууны арван нэгдүгээр үеийн засаг бэйс Бадрахын дөрөвдүгээр хатнаар залагдаж, Баянтолгой сүмээс зүүн өмнө тийш гучаад газар зайтай байрших Агитын цайдамд богтолж иржээ. Бадрахын үүдэнд хайрласан нэр нь Зандан, түүний Түмэдийн хошуунаас залсан болохоор “Түмэд хатан” гэдэг байжээ. Тэр үеийн Үүшин хошууны засаг ноён Бадрахын тамгын газар Агитын цайдамд байрлаж хэдэн ханан гэрээр нүүж сууж байсан аж. Бадрах ноён урд хожид гурван хатан залсан боловч нуган үр заяасангүй болохоор дөчин найман насан дээрээ Ордосын зүүн жигүүрийн өмнөт хошууны (зүүнгар) Хатан голын зүүн бие дэх Ордос нутаг лугаа залгаа байсан Сүйюань хотын харьяат онцгой хошуу баруун Түмэдийн нутгаас арван долоон настай Түмэд хатныг буулгаж иржээ. Дөрөвдүгээр хатны буулгах бүхий л явдлыг зүүнгар хошууны баруун туслагч зохицуулсан байна. Энэ нь Согсойбүрэн туслагчийн өмнө ор сууж байсан үнхэлцэг гэдэст (нэр нь хараахан тодроогүй) туслагч болно. Бадрах бэйс Түмэд хатныг буулгаж ирсэн дөрөвдүгээр жил Их Зуу чуулганы да ноёны оронд сууж их баяр найр хийжээ. 1858 онд хорин нэгэн настай Түмэд хатнаас агь Шагдарсүрэн мэндэлж, ноён суурины залгамжлах эзэнтэй болсон нь баяр дээр баяр давхацсан байжээ. Түмэд хатан сэхээтний гэр бүлд төрж, хятад монгол холилдон суурьшсан газар өссөн болхоор монгол нанхиад хэлийг төгс эзэмшсэн нэгэн байжээ. Тэрээр төрөлхийн ухаалаг сэцэн нь хэтийдсэн бүсгүй байсан төдийгүй үндэс угсаа залгамжлах хөвүүнийг төрүүлсэн учраас байр суурь нь ихээхэн батажсан байлаа. Тэрээр гэр бүлийн ажил хэрэг зохицуулахд ур дэмтэй байснаар барахгүй, нийгмийн харилцаанд чадамгай болохоор хошуу засгийн үйл хэрэгт оролцож зөвөлгөө хийх эрхтэй болсон байжээ. Тэр үес баруун хязгаарт хотонгийн үймээн дэгдэж эхэлсэн болхоор аймаг чуулганы ажил алба маш тулгам болж, улаа бошго өдөржин давхилдаж байв. Тухайн үед хошуу засаг бөгөөд Их Зуу чуулганы да ноён Бадрахын шадар туслагч нь Балжир гүн байж, өдөржин бийр намируулан алба ажил шийтгэж, бусад цагт нь морин дэл дээгүүр хийсгэж борви бохисхийх завгүй яарч явдаг байжээ.

Алтан ургийн сурвалжит үүдэнд төрсөн Балжир тайж бага балчир насандаа тавдугаар дүү Рагважамсаны хамт Гүмбүм хийдэд хүрч төвд номыг гүнзгий сурсан түүхтэй. Нутагтаа буцаж ирсний дараа эцэг ноёны ор залгамжлах боломж гарсан тул шар шувталж, зүүн хойт орноос гэрийн багш залж ирээд монгол манж бичгийг шамдан сурсан байв. Балжир тайж ер бусын ой билэгтэй авьяаслаг мэргэн хүн байсан тул хэдэн жилийн чармайлгыг өнгөрөөгөөд монгол, төвд, манж гурван хэлний бичигт боловсронгуй, албаны бичиг зохион бичих гарамгай чадалтай болжээ.

Тэр цагт өргөмжлөлт сэцэн хатан ногоон торгон тэрлэг дээрээ гарди хатгамалсан улаан торгон ханжаар давхарлаж, дээгүүр нь луу гардийн шивээстэй хөх цэнхэр өнгийн

хөлмөг нөмөрдөг байжээ. Түүнд бас Манжийн хаанаас шагнасан морин цагаан сувдаар ханын эрээн хээ угалз гаргаж хэлхсэн «сувд орхиул» хэмээх цацаг зангидсан «эрдэнийн алчуур» байсан байна. Тэрээр хурим найрт морилохдоо эрдэнийн алчуураар дал мөрөө бүрхэн хүзүүндээ сулхан зангиддаг байсан бөгөөд энгэртээ алт шарсан бэлгэт гөрөөсөн гуу зүүж, дотор нь гүгэл зандан зэрэг үнэрт эд агуулсан гурван мөрт чимэглэлийн хавтага энгэрийн товчоос унжуулдаг зуршилтай байжээ. Хүзүүндээ буурцгийн чинээ мөхлөгтэй сувдан сондор буюу жижиг мөнгөн хонх зүүж, хөлдөө хатгамал хуартай хилэн махай өмсдөг байсан баримт байна. Ажил албаар гадагш гарахдаа өнгөт шүр, ногоон хас, тогос чулуу, номин, сувд хэрэглэж, алт мөнгөөр хээлж урласан арван найман жингийн хүнд даруулга зүүгээд ойр ойрхон намбатай гишгэлэн шалмаг алхалж явахдаа хүдрийн заарын үнэр анхилуулж, сувд шүрэн шигтгээтэй суунаг жич эрвээхэй, загасан хээтэй унжилга бүхий жижиг хонхнууд нь хоорондоо харгалдаад жингэнэн хангирсч хүмүүсийн хайр бахархлыг жигтэйхэн татдаг байсан тухай хэлэлцдэг байна.

Дээр дурдагдсан Балжир гүн болбоос Манжийн төрд нөлөө ихтэй жанжин байсан болхоор энэ харьцаагаа ашиглан хошуу тусгаарлах оролдлого хийж, тэр нь ихээхэн бүтэлтэй байсан гэдэг. Балжир гүн нэг талаар хошуу тусгаарлах ухуулга хийж, нөгөө талаар өргөмжлөлт Сэцэн хатныг Баруун Шанд урьж авчран төвд бичиг зааж энхрийлж, эрхлүүлж эрх дураар нь байлгаж байжээ.

Тайж Дамиранжав, чуулганы дэд да Балжир гүн, өргөмжлөлт Сэцэн хатан хоёул алба ажил, бурхан ном хэмээн төр шажиныг зэрэгцүүлж, салалгүй шахам хэлхэлдэж байгааг үзээд энэ тухайд хожмын хэрэгт тустай болно хэмээж <<Хавар цаг>> гэх дууны аялгыг ашиглан <<Амрагийн магтуу>> хэмээх 17 бадаг дуу гаргасан нь дээрхи Түмэд хатанд зориулсан дуу бөгөөд Ордос нутагт ихээхэн тархсан билээ.

Ийнхүү нэгэнтээ түүх болон үлдсэн дээрхи дууны талаархи судалгааны хүрээнд судлаачдад хэрэг болох болов уу, хэмээн уг дууны шүлгийг бүрнээр нь хүргэж байна. Жич: Монгол бичгээс буулгасан болно.

Дамиранжавын гаргасан “Сэчин хатны магтуу” дуунд:

01. Цугларсан олны дотроос шинжихлээр нь
Цолмон одны гэрэл мэт чивчисхийж байна
Чухам эрхэм чанарыг чинь асуухлаар нь
Чуулган аймаг хошуун дотор ердөө үгүй байна
02. Хавирганы чинь талаас харахулаа нь
Хар эрээн тогос шувуу адилхан байна
Ханилах сэтгэлийг чинь асуухулаа нь
Хамаг хүний дотроос ердөө үгүй байна
03. Царайны чинь өмнөөс харахулаа нь
Цагаан бадмаагийн цэцэг лүгээ адилхан байна
Чамлааран нийлэлдээд сууж байхула
Цагийн байдал нэмэгдсэн түүнээс илүү байна
04. Ар хойноос чинь харахула
Алтан шувуу нисэх шинж адилхан байна
Арга билэг хоёрыг чинь асуухулаа нь
Аймаг чуулган хошуун дотор ердөө үгүй байна
05. Бүрдсэн олон дотроос шинжихлээр нь

- Бүрхсэн өдөр гэгээн гэрэл гийсэн шинж байна
Бүхий хамаг сэтгэлийг чинь хэлэлцэхүүлэ
Бүгдийн чинь дотроос ердөө үгүй байна
06. Уран сайхан хэлэлцэх мэргэн үг чинь
Оломгүй далайны адилхан байна
Утга бодол төгссөн ухаан билгээс
Урссан уснаасаа тунгалагхан байна
07. Тэгш сайхан санаа сэтгэл чинь
Тэргэл сарны гэрэл шиг тунгалагхан байна
Дэвхэр сайхан бие янзыг нь үзэхүлээ нь
Тэнгэрийн үр хэмээмэнж нь ч чамаас илүүгүй
08. Зарим хүн авах дээрээ сонин байдаг юм даа
Жаахан тэгэсхийж байгаад байх нь олон бий
Залуу багаас өтөлтөл зангаар байдгийг
Зуун хүн дотроос нэгэн хоёр байна
09. Дэнсэлгэж ханилахын тэр үест
Дэмий хүн л дэлгэнэхийг байя гэсэн юм
Дэргэдэх хүндээ татагдсан байна
Тэгш сайхан санадагаас тэр яана буй
10. Солонгын өнгө гэрэл зүйлийн цэцэг шүү
Соно зөгий хураасан балын амт шүү
Сүрэг олон бүсгүй дотор чи минь үзүүр байна
Шөнийн олон одон доторх цолмон мэт байна
11. Харах хоёр нүд чинь мэлтэс хэмээжин
Хажууд нь ойртвол жамжаад авдаг юм
Ханцуйн дахи хоёр гар чинь найгас хэмээжин
Хавирганд нь хүрэлцвэл атгаад авдаг юм
12. Энх сайхан хоёулаараа хамт байсан хойно
Энэ төрөлдөө мартана гэх ч хаанаас байхав даа
Үүрд хоёулаараа зангаар байсан хойно
Өдөр сар удна гэх ч хаанаас байхав даа
13. Нүдний чинь зовхинд нь давхар хуштай
Нүгэлгүй харах чинь нэвт шувт байна
Нисваанисын үйлийн эрх үнэхээр хэцүү шүү
Нэг мөсөн салахгүй суувал ямар сайхан юм
14. Улаан хонгор царайг шинжихлээр нь
Удамбар цэцэг лүгээ нэгэн адил байна
Усгал сайхан ухааны чинь бодохулжин
Урсгал булгийн уснаасаа уян дөлгөөн байна
15. Үзтэл хоёул мэтийн янаг үгүй байна
Үйлийн үр эс болбол ерөөл заяа байна
Үнэн чин сэтгэл минь бат байсан хойно
Үргэлждээ мартана гэгч ердөө үгүй шүү
16. Хорь гаруй насан дээрээ төрүүлсэн юм байна
Хоёулаараа жигтэй болсон үнэн л байна шүү дээ
Хожимдоо олонхид суртал болохыг

Хойт үеийн залуучуудад дуулаад орхиё

17. Амь мэт хоёулаараа ханилсныг

Аль олон хүн бүрээс нууцлан явахдаа

Амраглан ханилсан энэ л журмыг

Арван долоон шүлэг болгон дуулаад орхъё доо” хэмээн нийт арван долоон бадаг дуулсан дуу байдаг.

НОМЗҮЙ

1. У. Загдсүрэн. “Бичмэл нэгэн дууны тухай”, “Монголын судлал” Улаанбаатар, 1971 (Tom, VIII)/p107~114[1].
2. А. Мостарт. “Ордос аман зохиол” Бээжин дэхи Католик шашны их сургуулийн хэвлэлийн хороо 1937 (II/№ 154) [2].
3. Найралт. Алтан-Оргил харгуулан тайлбарласан <<Гадаад монголын төрийг засах яамны хууль зүйлийн бичиг>> Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо 1989. 11/p457 [3].
4. Б. Хас-Эрдэнэ. “Баян толгой” Өвөр монголын сонин мэдээ хэвлэлийн товчоо (2012/№72)/p641-648 [4],[5],[6],[19].
5. Ч. Хасбилигт. “Богд Да ноён Бадрах” Үүшин хошууны улс төрийн зөвлөгөөний соёл түүхийн зөвлөл 1999,01/p40-41 [7].
6. Д. Бат. “Агваанчойдорын ярьсан монгол төвд бурхан шашны тухай аман яриа “Үндэсний хэвлэлийн хороо 2012/p173-177 [8].
7. Лян Ли Ши. “Алаша монголчуудын тухай судлал” Үндэсний хэвлэлийн хороо 2009,07/p155 [9],[12],[15],[17].
8. Содбилэг. “Чин улсын засгийн газраас баруун хойтын хотончуудын бослогыг дарангуйлсан дайны Их зуугийн чуулганд үзүүлсэн нөлөө”, (Өвөр монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл) 1996/№4/p90-91, 92-94 [9],[10],[20],[21].
9. ”Дайчин гүрний Мү Зүн Хуандийн магад хууль” (57-р боть, Бүрэнт Засагчийн 2(1863)дугаар оны 2-р сарын Хөх бичин өдрийн зурвас)[11],[13].
10. Цагаан-Дун. “Үүшин түүх” Үүшин хошууны монгол хэлбичгийн албан гэр/p105-106 [22], [23], [24], [25], [26], [27], [28], [31].
11. Чингэлт. Цагаанбар. “Үүшин түүхийн тухай Хатагин Цагаан-Дунын эрэгцүүлэл”. Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо 2011. 11 /p210-218 [47], [50], [51], [53], [54].
12. Боржигон Бат-Равдан. “Гарамгай уран сайханч Дамринжав хийгээд түүний зохиосон дуу шүлгийн тухай “,”Алтан гандир “сэтгүүл 1990 №1 / [48], [49].

Хоёр. Мэдээлэл авсан хүмүүс:

- ❖ Нансалмаа (1921-) [2009. 07. 20 Баян толгой гацааны арын улаан], Түүний эцэг шарилын энгэрт оршуулсан Бадрах да ноён болон Сэцэн хатны онгонд тахилга өргөж харж хамгаалдаг тайган хийж байжээ.
- ❖ Босвар (1922-) [2013. 02. 21 Божай гацааны шар тал][52].

- ❖ Баатар (1929-) [2013. 02. 22 Саруул нутаг гацааны улаан нуур] Масан удганы ач хөвүүн.
- ❖ Балжи (1936-) [2009. 07. 23 Үүшин зуу гацааны бунхан] Нагац өвөг Бор 12 настай тэр жил таалал төгссөн гэнэ. 16 хүн тужийн шангаас шарилын өнгөр хүргэсэн айхавтар хүнд байсан гэдэг. Ирээд арваад хонож байж хавдар харьсан гэдэг. 76 насалсан бунханд Бавуужавынд өнгөрөв.
- ❖ Үүшин хошууны архивын газрын мэргэжилтэн Шар элэг нутгийн Насанбат (1948-)-ын хууч [2002. 08. 08 тавцаг] [32].
- ❖ Үүшин хошууны баруун шины авхай Сэцэн ханру (1921-)-ын хууч [2010. 09. 14 Сосхой].


Гурав. Тайлбар сэлт:

ЗУРАГ 1.



Үүшин хошууны Баян толгой дахь шарилын энгэрт оршуулсан ноёны шарилыг харж хамгаалж, тайлгын үйлийг гүйцэтгэгч тайган Агсанборын охин Нансалмаа (1921-) болно.

ЗУРАГ 2.



Баруун шаныг сэргээн зурсан зураг.

ЗУРАГ 3.



Шинээр сэргээн зассан Их зуугийн сүм

Жич: Баруун өмнө доор нь байрших босоо оройтой жижиг дөрвөлжин барилга бол Бадрах ноён болон Сэцэн хатны хөвүүн, Үүшин хошууны арван нэгдүгээр үеийн засаг Шагдарсүрэн (1856-1927) Их зуу чуулганы дарга байсан хугацаандаа халхын тусгаар тогтнолыг ерөөж, Чингисийн онгонд байсан хар сүлдийг Их хүрээнд залж явуулах ажиллагааг санаачилан сэдсэн учир, заргад орсноос болж иргэн улсын засгийн газраас “Бүгд найрамдах хэрэгт эргэлзэх татгалзах санааныг агуулсан” хэмээн ял тулгаж тушаалаас огцруулагджээ.

SUMMARY

The song ‘Amrag hongoryn duulal’ /Lover’s song/ eulogizes the woman called Zandan, who is the youngest queen of lord, honored as ‘Smart queen’. Her beauties, her wisdom and her promise to live happy ever until her hair covered grey have been praised in the song.